

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС 2025 ОНЫ 7 ДУГААР САРЫН 28-НЫ
ӨДӨР МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ 85 ДУГААР ТОГТООЛД
ХЭСЭГЧИЛЭН ТАВЬСАН ХОРИГИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчилэн тавьсан хоригийг Төсвийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн хүрээнд тухайн тусгай хамгаалалттай газар нутагт байгаа алтны үндсэн ордуудтай холбогдох эдийн засгийн тооцоолол болон байгаль орчинд учруулах хор хохирол, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн эсэх, мөн алтны ордуудын нөөцийг нэмэгдүүлэх эрх зүйн орчны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан тусгай хамгаалалттай газар нутагт алт олборлох, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийгдсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, нэмэгдүүлэх бодлогыг баримтлах нь зүйтэй талаар үг хэлж, тухайн бүс нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан үнэ цэнэ, ач холбогдол, экологийн тэнцвэр алдагдах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавраас сэргийлэх зэрэг олон нөхцөл байдлын үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэсэгчилэн тавьсан хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар хориг тавьсан тухайн зүйл, хэсэг, заалт нэг бүрээр санал хураалт явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 85 хувь буюу 17 гишүүн хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн.

Харин Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 95 хувь буюу 19 гишүүн хүлээн авах боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчилэн тавьсан хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА**


Х.ГАНХУЯГ

